



2020

**ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**

хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоо

**ХУУЛЬ ЗҮЙН
СУДАЛГААНЫ
ТӨВ**

Захиалагч:

Улсын Их хурлын гишүүн Д.Цогтбаатар

Судалгааг хянасан:

С.Энхцэцэг ХЗҮХ-ийн захирал

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Бариаширсүрэн Хуульч, судлаач

Г.Халиунаа ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ахлах
ажилтан

Х.Ариунсүрэн ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний
ажилтан

АГУУЛГА	
УДИРТГАЛ	3
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	4
Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлын тухайд.....	5
Төрд үүсэх зардлын тухайд.....	7
НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ	9
Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох.....	9
Зардлыг тооцох.....	11
Ажлын хөлсийг тооцох.....	11
Хуулийн төсөлд хуулийн этгээдэд хүлээлгэж буй үүргийн дагуу үүсэх захиргааны зардал.....	12
Тоон үзүүлэлтийг тооцох.....	13
Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох.....	14
Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах.....	15
Нэмэлт зардлыг тооцох.....	16
Үр дүн, санал.....	16
ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦООЛОХ	18
Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо байгуулах, үүнтэй холбогдон гарах зардал.....	19
Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	20
Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо.....	20
Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах.....	22
Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох.....	24
Гарах зардлыг урьдчилан тооцох.....	24
Хүний нөөцийн зардал.....	24
Материаллаг зардал.....	27
Бусад зардал.....	28
Зардлыг нэгтгэн тооцох.....	29
Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах.....	29

Үр дүн, санал	29
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	31

УДИРТГАЛ

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Хууль тогтоомжийн тухай хууль”¹ болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”²-ын дагуу “Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”-ыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, энэхүү аргачлалын дагуу зардлын тооцоог хийснээр гарч болох зардлыг хэрхэн хэмнэх арга замыг эрэлхийлэх, мөн нэгэнт оршин буй тогтоцоог ашиглан уг эрх зүйн актын зорилгыг хэрэгжүүлж болох эсэх талаар тодорхой хувилбар бүхий санал, зөвлөмж гаргах боломжийг бүрдүүлдгээрээ давуу талтай юм.

Энэхүү зардлын тооцооны үндсэн зорилго нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргахад оршино.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл дэх зохицуулалтууд нь иргэнд зардал үүсгэхгүй, харин төрийн байгууллага болон хуулийн этгээдэд зардал үүсгэж байна. Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тоймлон гаргах, мөн эдгээр байгууллагад үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон. Мөн өмнө нь зардлын тооцоо хийгдэж байгаагүй тул энэ удаа хуулийн төсөл дэх зардал үүсгэх боломжтой зарим зүйл, заалтыг авч үзэн зардлыг тус тус тооцсон болно.

¹Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>

²Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://legalinfo.mn/annex/details/7336?lawid=11993>

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Хууль тогтоомжийн тухай хууль” болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл дэх зохицуулалтууд нь иргэнд зардал үүсгэхгүй, харин хуулийн этгээдэд болон төрд буюу төрийн байгууллагад зардал үүсгэж байна. Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх хуулийн этгээд болон төрд үүсэх зардлыг тоймлон гаргах, мөн үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд зардал үүсгэх боломжтой заалтуудыг бүхэлд нь авч үзэн тооцоолол хийх боломжгүй байх тул хуулийн төслийн 8, 9, 10, 11, 12, 13 дугаар зүйлийн зарим хэсгийг сонгон нэн тэргүүнд зайлшгүй шаардагдах зардлыг тус тус урьдчилан тооцсон болно.

Урьдчилсан байдлаар тоймлон гаргасан зардлын тооцооноос харахад нэг хуулийн этгээдийн тухайд зөвхөн хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасан 2 үүргийг хэрэгжүүлэхэд нийт **40,992** /дөчин мянга есөн зуун ерэн хоёр/ төгрөгийн захиргааны зардал үүсгэх магадлалтай. Гэхдээ хуулийн төслийн энэхүү заалтад хуулийн этгээдийн төрөлд ямар нэг хязгаар, ялгамжтай байдал заагаагүй бөгөөдхэрэв уг заалтыг улсын хэмжээнд бүртгэлтэй нийт **164,357** хуулийн этгээдэд үүрэг болговол зардлын хэмжээ нэлээд нэмэгдэхээр ажиглагдаж байх тул уг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдэд тодорхой хэмжээний хязгаарлалт тогоож өгөх нь зүйтэй гэж үзэн энэхүү зардлын хэмжээг бууруулах талаар боловсрууллаа. Саналыг энэ хэсгийн “хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлын тухайд” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.7 хэсэгт зааснаар Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангах үүргийг хүлээлгэсэн.

Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр төрд зардал үүсгэж буй зохицуулалтаас 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.2, 11.2.3 дахь хэсэгт заасан Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хороонд иргэний нийгмийн байгууллагыг төлөөлөх 4 гишүүнийг сонгон шалгаруулах ажиллагаатай холбогдох зохицуулалт, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэгт заасан Хорооны хурлыг сард

нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хуралдуулна гэх зохицуулалт, 13.2 дахь хэсэгт заасан Ажлын албыг үүсгэн байгуулахтай холбогдох зохицуулалтын хүрээнд хүний нөөцийн болон бусад зардлыг урьдчилсан байдлаар тооцож үзэхэд эн тэргүүнд төрөөс нэг жилд дунджаар **32,964,844**/гучин хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин дөрвөн/ төгрөгийн зардал үүсэхээр байна. Энэхүү зардалд шинэ тутам байгуулагдаж буй бүтцийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах бараа, эд хогшил худалдан авах санхүүжилтийн хэмжээг нэмж тусгах шаардлагатай юм. Мөн ажлын ачаалал, хуулийн хамрах хүрээнээс шалтгаалан бүтэц, орон тоонд өөрчлөлт орох боломжтойг анхаарах нь зүйтэй юм.

Мөн Хуулийн төслийн 8 дугаар зүйлд тусгасан нийтлэг үүргүүд болон 9 дүгээр зүйл дэх Төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүргийн хүрээнд Улсын Их хурал /9.1./, холбогдох төрийн байгууллага, цагдаагийн байгууллага /9.2.1/, хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллага /9.2.2./, гадаад улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Консулын газар зэрэг Монгол Улсыг төлөөлөн гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй /9.3./ байгууллагуудад хүлээлгэсэн үүргийн хүрээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хариуцах асуудлын хүрээг хуулийн төсөлд тодорхойгүй буюу хэт ерөнхий зохицуулсан нь үйл ажиллагааны болон чиг үүргийн хийдэл, давхардал, зөрчлийг бий болгох эрсдэлтэй байна.

Иймд хуулийн төсөл дэх хуулиар үүрэг хүлээлгэж буй зохицуулалтуудыг тодорхой болгох шаардлагатай. Мөн хуулийн төсөл дэх зарим нэр томъёог, тухайбал, “хүний эрхийг хамгаалагч”³, “үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх”, “мэдээллээр хангах” зэргийг хэрхэн ойлгох, түүний цар хүрээг тогтоох асуудлыг анхаарах, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шинэ бүтэц бий болгох шаардлагатай эсэх, эсхүл Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны ажил үүргийн хуваарьт нэмж тусган, Комисст шууд хариуцуулан өгч шийдвэрлэх боломжтой эсэхийг судлах, мөн хуулийн этгээдэд хүлээлгэж буй үүргийн цар хүрээ, хуулиар үүрэг хүлээх хуулийн этгээдийн хүрээг нарийвчлан тогтоох замаар тоог цөөлөх зэрэг арга хэмжээ авч зардлыг хэмнэх шаардлагатай гэж үзлээ.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлын тухайд

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 8 дугаар зүйл дэх нийтлэг үүрэг хүлээлгэх зохицуулалтууд хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн байна. Үүний дагуу хуулийн этгээд нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, хүний эрхийн хамгаалагч хүчирхийллийн бус, тайван замаар үйл

³Хуулийн төслийн 4.1.1. “хүний эрхийн хамгаалагч” гэж ганцаараа эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхиүлэн дэмжиж, тайван, хүчирхийллийн бус арга замаар хүний эрхэм чанарыг үндэсний болон олон улсын түвшинд хүндэтгэн хамгаалж байгаа хүнийг;

ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах /8.1.1/; хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрхийн хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх /8.1.2/; хүний эрхийн хамгаалагчдын талаарх ажиллагсдынхаа мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх /8.1.3/, хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах /8.1.4/ үүрэг хүлээнэ.

Хуулийн этгээдэд хүлээлгэсэн эдгээр үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан үүсэх захиргааны зардлын тооцоог дэлгэрэнгүй байдлаар судалгааны ажлын “Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг стандарт зардлын загвараар тооцох нь” хэсгээс үзэж танилцана уу.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн зүгээс тухайн үүргийг хэрэгжүүлэхэд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг⁴ тодорхойлж, тэдгээрийн тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоосон бөгөөд тухайн хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг зөвхөн мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргасан.

Хуулийн төслийн 8.1.3-д заасан үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тоо тодорхой бус байгаа тул нэг хуулийн этгээд уг үүргийг хэрэгжүүлэхэд нийт **40,992** /дөчин мянга есөн зуун ерэн хоёр/ төгрөгийн захиргааны зардал гаргахаар байна. Гэхдээ хуулийн төсөлд тусгагдсан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг, тухайлбал сургалтын танхимын түрээс, багшийн хөлс, цайны завсарлагын зардал зэрэг нэмэлт зардлыг тооцоогүй болно.

Дээрх зардлыг хэмнэх, үйл ажиллагааг хялбарчлах боломжийг судалсны үндсэн дээр үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжит хувилбарыг тогтоох зорилгоор тодорхой шалгуураар шалгаснаар хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчих, тэдэнд халдах магадлал бүхий салбар, чиглэл, үйл ажиллагааны төрөл зэргийг тодорхой заах замаар хуулиар үүрэг хүлээлгэх хуулийн этгээдийн тоог багасгах, сургалт, арга хэмжээний тоог албан хаагчдын мэдлэгийн төвшинд нийцүүлэн зохион байгуулах замаар давтамжийн тоог бууруулах арга хэмжээ авах хувилбарыг тус тус дэвшүүлсэн байна.

Дүгнэвэл, Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг хангах асуудалд ахиц дэвшил гаргасан, хүний эрхийг хангахад төрөөс авч хэрэгжүүлэх ажиллагааг олон улсын түвшин, чиг хандлагад нийцүүлэхэд чиглэсэн оновчтой ажлын нэг болох юм.

⁴Үүрэг тус бүрийн гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг стандарт үйл ажиллагаа гэнэ. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загварыг ЗГ-ын 2006 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 1-ээс үзэх боломжтой.

Түүнчлэн хуулийн төслийн 8.1.1 дэх хэсэгт заасан *хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, хүний эрхийн хамгаалагч хүчирхийллийн бус, тайван замаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах* үүргийг хэрэгжүүлэхэд үүсэх зардлыг тооцоолох боломжгүй. Учир нь хуулийн төслийн 4.1.1-д “хүний эрхийн хамгаалагч” гэж ганцаараа эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхүүлэн дэмжиж, тайван, хүчирхийллийн бус арга замаар хүний эрхэм чанарыг үндэсний болон олон улсын түвшинд хүндэтгэн хамгаалж байгаа хүнийг ойлгохоор томъёолсон нь хэт ерөнхий байх тул хүний эрхийн хамгаалагчийн тоог баримжаалан тогтоох боломжгүй, мөн “боломж бүрдүүлэх” гэдэгт ямар үйл ажиллагааг ойлгох нь тодорхойгүй байгаагаас гадна эдгээр үүргийг зөвхөн ажлын цагаар, эсхүл байнга хангах эсэх нь тодорхойгүй зэрэг шалтгааны улмаас үүсч болох зардлын хэмжээг тогтоох боломжгүй хэдий ч ихээхэн хэмжээний зардал үүсгэх магадлалтай байна.

Иймд дээрх үүргүүдийг хэрэгжүүлэх явцад хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээ хуулиар хамгаалахыг зорьж буй үйл ажиллагаатай хэрхэн дүйцэж байгааг анхаарах, дахин судалж үзэх шаардлагатай байна.

Төрдүүсэх зардлыг тухайд

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн төрд зардал үүсгэх 10, 11, 13 зүйл дэх зарим зохицуулалтын хүрээнд төрд үүсэх зардлаас нэн шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагааны зардлын хэмжээг урьдчилсан байдлаар тооцож гаргасан бөгөөд хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрөөс нэг жилд дунджаар **32,964,844** /гучин хоёр сая есөн зуун жаран төрвөн мянга найман зуун дөчин дөрөв/ төгрөгийн буюу хүний нөөцийн зардалд 11,489,357, материаллаг зардалд 21,475,487 төгрөгийн зардал үүсэхээр байна. Дэлгэрэнгүй тооцооллыг судалгааны ажлын холбогдох хэсгээс үзнэ үү.

Үүнээс гадна хуулийн төслийн 8 дугаар зүйлд тусгасан нийтлэг үүргүүд болон 9 дүгээр зүйл дэх Төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүргийн хүрээнд Улсын Их хурал /9.1./, холбогдох төрийн байгууллага, цагдаагийн байгууллага /9.2.1/, хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллага /9.2.2./, гадаад улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Консулын газар зэрэг Монгол Улсыг төлөөлөн гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй /9.3./ байгууллагуудад хүлээлгэсэн үүргийн хүрээнд үүсэх зардлыг тооцох шаардлагатай.

Хуулийн төслийн 12.1.4. хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч, Хүний эрхийн Үндэсний Комисст шилжүүлэн шийдвэрлүүлэх; 13.2. Хороо нь ажлын албатай байна. Хорооны ажлын албаны үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны бүтцэд бие

даасан нэгж гүйцэтгэнэ.” гэж заасанд үндэслэн Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах Хорооны Ажлын албыг бие даасан байдлаар шинээр үүсгэн байгуулахаас илүүтэй Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн “КомиссньМонголУлсынҮндсэнхууль, хууль, олонулсынгэрээндзаасанхүнийэрх, эрхчөлөөнийтухайзаалтынхэрэгжилтэдхяналттавьж, хүнийэрхийгсахинхамгаалах, хөхүүлэндэмжихбайгууллагамөн.” гэх үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцүүлэн, ажлын албанд хариуцуулах байдлаар шийдвэрлэх нь төрд үүсэх зардлыг хэмнэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. Энэхүү нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Комиссын хүний нөөцөд орох өөрчлөлт буюу нэмэлт зардал нь Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хорооны ажлын албыг шинээр үүсгэн байгуулах зардлаас эрс бага байна гэж судалгааны баг дүгнэлээ.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу алхам тус бүрийн хүрээнд мэдээлэл цуглуулан, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн дараахь тооцооллыг хийлээ.

Зардлын тооцоог дараахь алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
2. Зардал тооцох
3. Тоон үзүүлэлтийг тооцох
4. Зардлын дүнг тооцож гаргах
5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах
6. Нэмэлт зардал тооцох

Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсэгт төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдэд хүлээлгэсэн нийтлэг үүргийн хүрээнд хуулийн этгээдэд хүлээлгэсэн дараахь зохицуулалт байна.

Хүснэгт 1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалт

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүрэг
8.1.1.хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, хүний эрхийн хамгаалагч хүчирхийллийн бус, тайван замаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	1/ Хуулийн этгээдийн зүгээс явуулах боломж бүрдүүлэх, хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх,
	2/Хүний эрхийн хамгаалагчийг шаардлагатай мэдээллээр хангах
8.1.3.хүний эрхийн хамгаалагчдын талаарх ажиллагсдынхаа мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах.	1/Ажиллагсдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах,
	2/хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах,

Дээрх заалтуудад тусгагдсан үүргүүд нь мэдээллийн хэд хэдэн агуулгатай буюу хүний эрхийг хамгаалагчид зориулсан тодорхой арга хэмжээг тогтмол

хэрэгжүүлэх, боломж бүрдүүлэх зэрэг байнгын шинж чанартай үүрэг хүлээлгэж байгаа нь онцлог байна.

Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан мэдээллээс харахад 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт **164,357** хуулийн этгээд бүртгэлтэй байна.⁵

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь хэсэгт заасан үүргүүд нь хуулийн этгээдийн төрөлд ямар нэг хязгаар, ялгамжтай байдал заагаагүй тул дээр дурдсан 164 мянга гаруй хуулийн этгээдэд шууд хамааруулж ойлгох нь өрөөсгөл бөгөөд зардлын дүнг бодит бус гаргах магадлалтай гэж үзэн нэг хуулийн этгээдэд үүсч болох дүнгээр зардлыг тооцохоор шийдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан Хуулийн этгээдийн зүгээс хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, 2/ Хүний эрхийн хамгаалагчийг шаардлагатай мэдээллээр хангах үүргүүд нь тохиолдлын шинж чанартай үзүүлэх үйлчилгээнд байнгын бэлэн байдалд байх, Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан 1/Ажиллагсдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, 2/хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах үүргүүд нь нийт хуулийн этгээдэд тогтсон хугацаанд тодорхой давтамжтайгаар зохион байгуулах үүргийг тус тус хүлээлгэж байна.

Одоогоор хуулийн төслийн 8.1.1 дэх хэсэгт заасанчлан хүний эрхийг хамгаалагчдын зүгээс хуулийн этгээдээс ямар нэгэн мэдээлэл шаардсан, тухайн хуулийн этгээдтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа явуулж байсан талаар тодорхой тоо мэдээ, судалгаа байхгүй байгаа тул эдгээр зардлыг нарийвчлан тооцох боломжгүй юм.

Иймээс зөвхөн хуулийн төслийн 8.1.3-д заасан урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, сургалт зохион байгуулах зардлыг бусад чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний зардалтай жишин тооцож гаргахыг зорьлоо.

Стандарт үйл ажиллагаа, түүнд зарцуулах цаг хугацааг тооцохдоо аргачлалын гарын авлагад бичигдсэн стандарт үйл ажиллагааны жагсаалтын дундаж хугацааг жишиг болгон авсан болно.

⁵ОӨУБЕГ-ын захиргааны статистикийн мэдээлэл /2017 оны 11 дүгээр сар/. Эх сурвалж: <http://burtgel.gov.mn/index.php/news/statistical-rating-item>. Сүүлд нэвтэрсэн 2017.11.28

Хүснэгт 1. Стандарт үйл ажиллагааны зардлыг тооцох нь

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Давтамж	Зардал (төг)
хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах	8.1.1. Урьдчилсан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үүрэгтэй танилцах	3	2	6
		Мэдээлэл цуглуулах	120	2	240
		Санхүүгийн тооцоо гаргах	20	2	40
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5	2	10
		Дотоод хуралдаан	30	2	60
		Алдааг засах	20	2	40
		Нийт	198	2	396
	Арга хэмжээ зохион байгуулах	Үүрэгтэй танилцах	3	2	6
		Бусадтай хамтран хийх хуралдаан	30	2	60
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8	2	16
		Олшруулах, архивлах, тараах	5	2	10
		Нийт	46	2	92

Зардлыг тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргах ба хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг⁶ тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо 1/ үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох; 2/ тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох; 3/ тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлохгэсэн 3 хүчин зүйлийг тооцов. Үүнд:

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо Үндэсний статистикийн хорооноос тогтмол хугацаанд гаргадаг аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсний 2017 оны 3 дугаар улирлын дунджийг баримжааланажилтны нэг

⁶Үүрэг тус бүрийн гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг стандарт үйл ажиллагаа гэнэ. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загварыг ЗГ-ын 2006 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 1-ээс үзэх боломжтой.

сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хуваах замаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргасан.

Хүснэгт 2. Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин⁷

Он	2014 онд	2015 онд	2016 онд	2017 онд	Дундаж дүн
Улсын дундаж цалин	844,000	868,500	884,300	955,900	888,175

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалин сүүлийн дөрвөн жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Сүүлийн дөрвөн жилийн дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг **888,175** төгрөг байхаар, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байх тухай зохицуулалтад үндэслэн тооцов.⁸

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын хөлсийг цаг, минутаар

Үндсэн цалин	/	Ажиллах хугацаа	=	Ажлын хөлс /төгрөг/
888,175	/	176 цаг	=	5,046 төг /цагт/
888,175	/	10560 минут	=	84 ⁹ төг /минут/

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд хүлээлгэж буй үүргийн дагуу үүсэх захиргааны зардал

Хуулийн төслийн 8.1.3-д заасан Хүний эрхийг хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажил тогтмол зохион байгуулах, хүний эрхийг хамгаалагчдын талаарх ажиллагсдынхаа мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулахад хуулийн этгээдийн зүгээс гарах зардлыг тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаагаар үржүүлэн тус бүрийн зардлыг гаргасан.

⁷2017 оны 3 дугаар улирлын байдлаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, өмчийн хэлбэр, хүйс, улирал, жилээр. Цахим хаяг: Сүүлд нэвтэрсэн 2017.12.17-ны өдөр. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0400_021V1&S0UM_select_all=0&S0UMSingleSelect=0&Gender_select_all=0&GenderSingleSelect=1&Year_select_all=0&YearSingleSelect=201703&viewtype=table

⁸Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

⁹Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны 1 цагийн хөлс 84,10 төгрөг байгаа бөгөөд энэ тохиолдолд 84 төгрөг болгон тэгшитгэсэн болно.

Хүснэгт 4. Зардал. Хугацаа х Ажлын хөлс = Үйл ажиллагаа тус бүрийн зардал

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Ажлын хөлс (төг)	Зардал (төг)
хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах	8.1.1.Урьдчилсан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үүрэгтэй танилцах	3	84	252
		Мэдээлэл цуглуулах	120	84	10080
		Санхүүгийн тооцоо гаргах	20	84	1680
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5	84	420
		Дотоод хуралдаан	30	84	2520
		Алдааг засах	20	84	1680
		Нийт	198	84	16632
	8.1.1.Арга хэмжээ зохион байгуулах	Үүрэгтэй танилцах	3	84	252
		Бусадтай хамтран хийх хуралдаан	30	84	2520
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8	84	672
		Олшруулах, архивлах, тараах	5	84	420
		Нийт	46	84	3864

Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлэх ба түүнийг тооцохдоо тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо) болон тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо)гэсэнхүчин зүйлийг тооцов. Үүнд:

Тохиолдлын тоо: Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан үүргүүд нь хуулийн этгээдийн төрөлд ямар нэг хязгаар, ялгамжтай байдал заагаагүй тул эдгээр үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн нэгдсэн тоог гаргах боломжгүй байгаагаас үүдэн нэг хуулийн этгээдэд үүсч болох зардлаар үнийн дүнг тооцов.

Давтамжийн тоо: Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан үүргүүдийг тогтмол зохион байгуулж байхаар зохицуулсан тул давтамжийг 2 буюу хагас жилд 1 удаа зохион байгуулна гэж авсан болно.

Хүснэгт 6. Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо x Давтамж

Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	
хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах	Үүрэгтэй танилцах	1	2	2	
	Мэдээлэл цуглуулах	1	2	2	
	Санхүүгийн тооцоо гаргах	1	2	2	
	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	1	2	2	
	Дотоод хуралдаан	1	2	2	
	Алдааг засах	1	2	2	
	Нийт				
	Үүрэгтэй танилцах	1	2	2	
	Бусадтай хамтран хийх хуралдаан	1	2	2	
	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	1	2	2	
	Олшруулах, архивлах, тараах	1	2	2	

Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 7. Нийт зардал = Стандарт үйл ажиллагааны зардал x Тоон үзүүлэлт

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал	
хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах	8.1.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үүрэгтэй танилцах	252	2	504	
		Мэдээлэл цуглуулах	10080	2	20.160	
		Санхүүгийн тооцоо гаргах	1680	2	3.360	
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	420	2	840	
		Дотоод хуралдаан	2520	2	5.040	
		Алдааг засах	1680	2	3.360	
		Нийт				33.264
	8.1.1. Арга хэмжээ зохион байгуулах	Үүрэгтэй танилцах	252	2	504	
		Бусадтай хамтран хийх хуралдаан	2520	2	5.040	
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	672	2	1344	
		Олшруулах, архивлах, тараах	420	2	840	
		Нийт				7.728
	Нийт зардал					40.992

Үүнээс үзэхэд хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан Хүний эрхийг хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажил тогтмол зохион байгуулах, хүний эрхийг хамгаалагчдын талаарх ажиллагсдынхаа мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулах /хагас жил тутамд нэг удаа буюу жилд хоёр удаа/ үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдээс **40,992** /дөчин мянга есөн зуун ерэн хоёр/ төгрөгийн захиргааны зардал шаардагдахаар байна.

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Шалгуурууд:

- Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Хуулийн төсөлд тусгагдсан үүргийг хэрэгжүүлэх ажиллагаанд цахим хэлбэрийг ашиглах бүрэн боломжтой. Гэвч дээрх хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлын тооцоо нь зөвхөн сургалтын хөтөлбөр боловсруулах, ажлын байранд сургалт зохион байгуулах стандарт үйл ажиллагааны зардлыг тооцсон байх тул дээрх нийт зардлын дүнд цахим хэлбэрийг ашигласантай холбогдуулан томоохон хэмжээний өөрчлөлт орох боломжгүй юм.
- Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх: Энэ тохиолдолд хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах, хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчих, тэдэнд халдах магадлал бүхий салбар, чиглэл, үйл ажиллагааны төрөл зэргийг тодорхой болгох замаар тохиолдлын тоо буюу хуулиар үүрэг хүлээх субъектын тоог багасгах боломжтой.
- Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх: Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь хэсэгт заасан 1/Ажиллагсдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, 2/хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах үүргүүд нь нийт хуулийн этгээдэд тогтсон хугацаанд тодорхой давтамжтайгаар зохион байгуулах үүргийг тус тус хүлээлгэж байна. Иймээс хуулийн этгээдэд ажиллагсдын хүний эрхийг хамгаалагчдын талаарх мэдлэг, ойлголтын төвшнөөс хамааран сургалт зохион байгуулах давтамжийг тогтоох нь илүү үр дүнтэй байх магадлалтай.
- Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх, Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх: Энэ тохиолдолд мэдээллийн агуулгыг хэрхэн тодорхойлох нь буюу хэр өргөн эсхүл бага цар хүрээг хамарсан сургалт, арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь тухайн хуулийн этгээдийн дотооддоо шийдвэрлэх асуудал тул мэдээллийн агуулгад өөрчлөлт оруулах эрх хуулийн этгээдэд олгогдсон байна.

Нэмэлт зардлыг тооцох

Хуулийн төсөлд тусгагдсан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг, тухайлбал хөндлөнгийн хяналт шинжилгээ хийлгэх төлбөр, сургалтын танхимын түрээс, багшийн хөлс, цайны завсарлагын зардал зэрэг нэмэлт зардлыг тооцоолно. Гэхдээ Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд заасан үүргүүдийг хуулийн этгээд өөрийн дотоод нөөц бололцоондоо түшиглэн хэрэгжүүлнэ гэж үзэн энэ удаад нэмэлт зардлыг тооцоогүй болно.

Үр дүн, санал

1. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгасан “Хуулийн этгээдийн зүгээс хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, 2/ Хүний эрхийн хамгаалагчийг шаардлагатай мэдээллээр хангах үүргүүд нь тохиолдлын шинж чанартай үзүүлэх үйлчилгээнд байнгын бэлэн байдалд байх” үүргийг хэрэгжүүлэхэд гарах захиргааны зардлын тооцоог хийх боломжгүй байна. Учир нь “үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх” үүргийн хүрээнд хуулийн этгээд хэнд, хэзээ, ямар тохиолдолд, хэр хэмжээнд үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх үүрэгтэй нь, мөн “шаардлагатай мэдээлэл”-ийн цар хүрээг тогтоогоогүй байгаа нь тухай хуулийн этгээдтэй холбоотой бүхий л мэдээлэл хамаарахаар байгаа тул дээрх үүргүүдийн зардлыг тооцох боломжгүй гэж үзсэн. Иймд хуулийн төсөлд
 - хүний эрхийг хамгаалагч гэж хэнийг ойлгох тухай тодорхойлолтыг илүү нарийвчлах,
 - түүн дотроо хуулийн этгээдээс мэдээлэл шаардах, үйл ажиллагаа явуулах эрхийг бүх хүний эрхийг хамгаалагчид олгох эсэхийг тодорхой болгох,
 - үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх, мэдээллээр хангах үүргийг хуулийн этгээд хэзээ, ямар шаардлага хангасан хүний эрхийг хамгаалагчид өгөх зохицуулалтыг нарийвчлан тусгах, тухайлбал ажлын бус цагаар мэдээлэл шаардах эрхтэй эсэхийг нарийвчлан тусгах,
 - мөн хүний эрхийн хамгаалагчийн зүгээс шаардаж болох мэдээллийн цар хүрээг тодорхойлох асуудлыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай гэж үзлээ.
2. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан 1/Ажиллагсдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, 2/хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах үүргүүд нь хуулийн этгээдийн төрөлд ямар нэг хязгаар, ялгамжтай байдал заагаагүй тул эдгээр үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн нэгдсэн тоог гаргах боломжгүй байгаагаас үүдэн нэг хуулийн этгээдэд үүсч болох зардлаар тооцон хуулийн

этгээдэд **40,992** /дөчин мянга есөн зуун ерэн хоёр/ төгрөгийн захиргааны зардал үүсгэхээр байна.Хэрэв хуулийн төслийн энэхүү заалтыг улсын хэмжээнд бүртгэлтэй нийт 164357 хуулийн этгээдэд үүрэг болговол зардлын хэмжээ нэлээд нэмэгдэх тул уг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдэд тодорхой хэмжээний хязгаарлалт тогоож өгөх нь зүйтэй юм. Энэхүү зардалд зөвхөн сургалт, арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай хамгийн наад захын стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх зардлыг тооцсон бөгөөд үүнээс гадна үүсч болох сургалтын танхимын түрээс, багшийн хөлс, цайны завсарлагын зардал зэрэг нэмэлт зардлыг тооцоолоогүй тул эдгээр үйл ажиллагаатай холбоотой үүсэх нэмэлт зардал дээрх зардлын хэмжээг нэмэгдүүлэх нь тодорхой юм. Хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах зорилгоор дараахь асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

- Сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хугацаанд зохион байгуулах шаардлагатай хуулийн этгээдийн төрлийг үйл ажиллагааны чиглэл, үйлчлүүлэгчдийн хүрээг харгалзан нарийвчлан тогтоох замаар хуулийн этгээдийн тоог багасгах боломжийг судлах,
- Сургалт, арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай сургалтын нэгдсэн хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний загварыг Ажлын албанаас боловсруулж хуулийн этгээдэд хүргүүлснээр тухайн хуулийн этгээдэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахтай холбогдон үүсэх зардлыг багасгах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлах,
- Эдгээр сургалт, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн, хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих, дүн шинжилгээ хийх эрх бүхий субъектыг тодорхойгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хяналт шинэжилгээ хийх асуудал хангалтгүй байх үндэслэл болох магадлалтай байгаад анхаарах шаардлагатай байна.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦООЛОХ

Энэ бүлэгт хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зарим зохицуулалтууд нь төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох юм. Захиргааны байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд тусгасан нийтлэг үүргүүд болон 9 дүгээр зүйл дэх Төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүргийн хүрээнд Улсын Их хурал /9.1./, холбогдох төрийн байгууллага, цагдаагийн байгууллага /9.2.1/, хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллага /9.2.2./, гадаад улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Консулын газар зэрэг Монгол Улсыг төлөөлөн гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй /9.3./ байгууллагуудад үүрэг хүлээлгэсэн байна.

Ялангуяа гадаад улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн хамгаалагч Монгол Улсын иргэний эрхийг хамгаалах чиглэлээр хүлээлгэж буй үүргүүд нь өргөн цар хүрээг хамарсан, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэр зэргийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Тухайлбал хуулийн төслийн 9.3.3-д хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлын талаар хяналт шинжилгээ хийх, мэдээлэх, 9.3.9-д хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн боломжит арга хэмжээ авах; 9.3.10-д нэн тэргүүнд шаардлагатай санхүүгийн туслалцаа үзүүлэх зэрэг үүргийг энд дурдаж болох юм.

Хуулийн төсөлд төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа буюу ажил үйлчилгээ тус бүрийг стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож эдгээрт ямар цаг хугацаа зарцуулах хэрэгцээтэй болохыг тогтоодог. Тухайн үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацааг тодорхойлсноор тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох бөгөөд улмаар улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал үүсэхийг урьдчилан тооцох боломжтой. Гэвч хуулийн төслийн Гуравдугаар бүлэг дэх зохицуулалтын хүрээнд төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааг нэг бүрчлэн тооцоход шаардлагатай төрийн байгууллагаас авч болох тоо мэдээлэл хомс, энэ талаарх мэдээллийг тусгайлан бүртгэдэггүй, мэдээлэл төвлөрсөн газар байхгүй, мөн хүний эрхийг хамгаалагч буюу энэ тодорхойлолтод

хамаарч болох этгээдийн зүгээс гаргасан хүсэлт, шаардлага зэрэгт холбогдох судалгаа байхгүй, дүйцүүлэх боломжгүй байгаа нь зардлыг бодитоор урьдчилан тооцоход хүндрэлтэй нөхцөлийг үүсгэж байна. Үүнээс үүдэн судалгааны үр дүн бодит байдалд нийцэхгүй байх эрсдэл өндөр байх тул энэхүү судалгаагаар зөвхөн хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг дэх Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо, түүний ажлын албыг шинээр үүсгэн байгуулахад төрөөс шаардагдах зардлыг урьдчилсан байдлаар тооцоолон гаргахыг зорилоо.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд энэ хуулийг хэрэгжүүлэх гол субъект болох Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо, түүний ажлын алба гэх 2 шинэ бүтцийг бий болгохоор тусгасан байна.

Эдгээр бүтцийг шинээр бий болгоход улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараахь үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо, түүний ажлын албыг байгуулах, үүнтэй холбогдон гарах зардал;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо байгуулах, үүнтэй холбогдон гарах зардал

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 10, 11, 12, 13 дугаар зүйлд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо, хорооны гишүүнийг сонгох, хорооны бүрэн эрх, түүний ажлын зохион байгуулалтын талаарх зохицуулалт орсон байна. Дээрх зохицуулалтуудаас харахад уг Хорооны үйл ажиллагаатай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комисс, түүний дэргэдэх Орон тооны бус зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам зэрэг төрийн байгууллагууд хуулиар тогтоосон үүрэг хүлээж байна.

Иймд хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд уг хуулийн хэрэгжилтийг хангахад гол үүрэг гүйцэтгэх үүрэг хүлээсэн Хороо, түүний ажлын албыг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах тухай зохицуулалттай холбогдон үүсэх магадлалтай зардлыг урьдчилан тооцох болно.

Уг хуулийн төсөлд тусгаснаар Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо нь дарга, төр, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн 6 гишүүнтэй /10.3./ байх ба хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах үйл ажиллагааг эрхлэн явуулах үүргийг хэрэгжүүлэн /10.1./ Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд бие даасан, хараат бус байдлаар ажиллах /10.2./ бөгөөд сард нэгээс доошгүй удаа хуралдах үүрэг

хүлээсэн /13.1.1./. Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангахаар /10.7./ зохицуулсан байна.

Хорооны дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга байх бөгөөд гишүүдэд Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын асуудал хариуцсан нэгжийн удирдлага, Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Бодлогын хэрэгжилт хариуцсан нэгжийн удирдлага, Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшин сонгогдсон дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна. /10.4. гэж заасан.

Хуулийн төслийн 13.2.-т Хороо нь ажлын албатай байна. Хорооны ажлын албаны үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны бүтцэд бие даасан нэгж гүйцэтгэнэ гэж заасан бөгөөд ажлын албаны ажиллах журмыг Хороо батлахаар тусгасан байна.

Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хамгаалах хороо, түүний ажлын албаны үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлоход юуны өмнө тодорхой тоо баримт шаардлагатай болдог. Эдгээр тоо баримт нь өнгөрсөн хугацаанд хүний эрхийг хамгаалагчдад халдсан, тэдний эрх ашгийг хамгаалах хэрэгцээ шаардлага, бүртгэлд тулгуурласан байх нь зохимжтой байдаг.

Гэвч хуулийн төслийн хүрээнд авч үзсэн “хүний эрхийг хамгаалагч”-ийн тодорхойлолт хэт ерөнхий байх тул үүнд хамаарах этгээдийн тоог баримжаалан тогтоох боломжгүй, хүний эрхийг хамгаалагчдын зүгээс гаргасан өргөдөл, гомдлын тоо мөн адил тодорхойгүй зэрэг хүндрэл бэрхшээлээс үүдэн ажлын албаны ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох боломжгүй байлаа.

Иймд хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ажлын хүрээнд Хорооны хурал зохион байгуулах иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшиж буй гишүүдийг сонгон шалгаруулах ажиллагаатай холбоотой үүсэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон болно.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороо

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хорооны тухай зохицуулалт орсон байна. Үүнээс үзэхэд Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд үйл ажиллагаа явуулах энэхүү хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд дарга, 6 гишүүнтэй байна. Хорооны дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүд нь Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын асуудал хариуцсан нэгжийн удирдлага, Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Бодлогын хэрэгжилт хариуцсан нэгжийн удирдлага, иргэний

нийгмийн байгууллагаас нэр дэвшин сонгогдсон дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Хорооны бүтэц, зохион байгуулалтыг харахад дарга болон гишүүдийн 2 нь төрийн болон төрийн захиргааны төв байгууллагад хариуцсан албан тушаалын дагуу гишүүнээр сонгогдож байгаа бол үлдсэн 4 гишүүн иргэний нийгмийн байгууллагаас сонгогдохоор зохицуулсан.

Хорооны гишүүдийн цалин хөлс, шагнал, урамшлын талаар зохицуулалт байхгүй байна. Хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагаас харахад “Хорооны гишүүд сайн дурын үндсэн дээр цалин хөлс, ямар нэг урамшил авахгүйгээр ажил үүргээ гүйцэтгэнэ, харин Төрийн байгууллагаас хариуцсан албан тушаалын хувьд гишүүнээр сонгогдож буй гишүүд албан тушаалын цалингаа авч байгаа учраас Хорооны гишүүн гэдэг утгаараа цалин урамшил авахгүй гэж бодож байна.”¹⁰ гэж тайлбарласан. Иймд хорооны гишүүдэд аливаа урамшуулал, цалин хөлс олгохгүй гэж үзэн энэхүү үйл ажиллагаанд зардал тооцоогүй болно.

Хуулийн төслийн 13.1.1.-д Хорооны хурлыг сард нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хуралдуулна гэж заасан. Хуралдааны зардлыг тооцохдоо ээлжит бус хуралдааны зардлыг оруулалгүй зөвхөн нэг сард нэг удаа буюу 1 жилд 12 удаа хуралдуулахаар тооцсон болно.

Хүснэгт №3. Хорооны хуралдааны зардал

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/минут
Хорооны хурлыг сард нэгээс доошгүй удаа	Мэдээлэх үүрэгтэй танилцах	3	12	36
	Мэдээлэл цуглуулах	3	12	36
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах	10	12	120
	Дотоод хуралдаан	30	12	360
	Шийдвэрийг албажуулах	15	12	180
	Олшруулах, архивлах, тараах	2	12	24
	Нийт		63	12

¹⁰Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн хурлын тэмдэглэлээс

Үүнээс үзэхэд Хорооны хурлыг зохион байгуулахад жилд дунджаар 756 минут буюу 12,6 ажлын цаг шаардагдах ба энэ нь 1,57 хүний нөөцийн хэрэгцээг илэрхийлж байна

Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дугаар зүйлд иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшүүлэх Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг тусгасан.

Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшиж буй 4 гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой нэг жилд үүсэх зардлыг тооцохдоо тохиолдлын тоог 4 гишүүний тоогоор, давтамжийн тоог хуулийн төслийн 11.4.-д Хорооны дөрвөн гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх ба нэг удаа улируулан сонгож болно гэж заасны дагуу 0,2 байхаар тооцов.

Хүснэгт №7. Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах стандарт үйл ажиллагаа, хугацаа

Хорооны гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минут
11.2.1. Хүний эрхийн Үндэсний Комисс нээлттэй нэр дэвшүүлэх зарыг 6 сараас доошгүй хугацааны өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсаар түгээнэ	Мэдээлэх үүрэгтэй танилцах	3	4	0,2	2,4
	Мэдээлэл цуглуулах	3	4	0,2	2,4
	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	1	4	0,2	0,8
	Мэдээлэл шилжүүлэх ба нийтлүүлэх	10	4	0,2	8
	Олшруулах, архивлах, тараах	2	4	0,2	1,6
	Нийт		19	4	0,2

11.2.2.Хүний эрхийн Үндэсний Комисс, тус комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөл, иргэний нийгмийн төлөөлөл бүхий ажлын хэсэг /цаашид ажлын хэсэг гэх/ нээлттэй зар түгээснээс хойш 6 сарын дараа нэр дэвшигчдийн жагсаалтыг нэгтгэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албаны цахим хуудсаар танилцуулна.	Мэдээлэх үүрэгтэй танилцах	3	4	0,2	2,4
	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	1	4	0,2	0,8
	Тоо баримтыг боловсруулах	15	4	0,2	12
	Мэдээлэл шилжүүлэх ба нийтлүүлэх	10	4	0,2	8
	Олшруулах, архивлах, тараах	2	4	0,2	1,6
	Нийт	31	4		24,8
11.2.3.Ажлын хэсэг энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчдийг оролцуулсан нээлттэй сонголт хийж, нэр дэвшигчдийн талаар хэлэлцүүлэг явуулна	Мэдээлэх үүрэгтэй танилцах	3	4	0,2	2,4
	Мэдээлэл цуглуулах	3	4	0,2	2,4
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах	10	4	0,2	8
	Бусадтай хамтран хийх хуралдаан	60	4	0,2	48
	Шийдвэрийг албажуулах	15	4	0,2	12
	Олшруулах, архивлах, тараах				

		2	4	0,2	1,6
	Нийт	93	4		74,4
	НИЙТ	143			114,4

Үүнээс үзэхэд иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшиж буй Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 5 жил тутамд 1 удаа зохион байгуулахад жилд дунджаар 114,4 минут буюу 1,9 **ажлын цаг** шаардагдах ба энэ нь 0,23 **хүний нөөцийн хэрэгцээг** илэрхийлж байна

Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалтаар зөвхөн хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хорооны хурал зохион байгуулах болон хорооны гишүүдийн сонгон шалгаруулах тухай хуулиар хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэхэд **1,8** хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтайг юм. Гэхдээ хуулийн төслийн 11.2.1.-д Хүний эрхийн Үндэсний Комисст нээлттэй нэр дэвшүүлэх зарыг түгээх үүрэг хүлээлгэсэн нь зарим үйл ажиллагаатай холбогдуулан Комисс, түүний дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн хүний нөөцийн хэрэгцээнд өөрчлөлт орох нөхцөлийг бүрдүүлж байна.

Гарах зардлыг урьдчилан тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал/
- Материаллаг зардал /төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хорооны ажлын албанд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн 11 орон тоотойгоор төсөөлөн хүний нөөцийн зардлын тооцоог гаргасан.

Хүснэгт №11 Ажлын албаны албан хаагчдын цалингийн зэрэглэл

№	Албан тушаал	Хариуцах чиглэл	Албан тушаал эрхлэгчийн тоо
1.	Ажлын албаны дарга		1
2.	Гомдол, хяналт шалгалт хариуцсан референт	12.1.4.хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч, Хүний эрхийн Үндэсний Комисст шилжүүлэн шийдвэрлүүлэх; 12.1.5.хүний эрхийн хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлын дагуу түүнийг таслан зогсооход чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авах; 12.1.6.эрсдэлийн үнэлгээ хийх, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад шаардагдах хэрэгцээг тодорхойлох;	2
3.	сургалт, сурталчилгаа хариуцсан референт	12.1.1.хүний эрхийн хамгаалагчид халдах, эрхийг нь зөрчихөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах;	1
4.	хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан референт	12.1.10.үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулж, олон нийтэд тогтмол мэдээлж байх; 12.1.7.хүний эрхийн хамгаалагчид халдсан хэргийг мөрдөн шалгах явцад туслах, дэмжих, мэдээлэх, зөрчил гаргагчид хариуцлага хүлээлгэсэн эсэхийг мэдээлэх;	1
5.	Олон талт хамтын ажиллагаа хариуцсан ажилтан		1
6.	Судалгаа, шинжилгээ хариуцсан ажилтан	12.1.9. Монгол Улсын хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлыг “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-д тусгах.	1
7.	Архив, албан хэрэг хариуцсан ажилтан	12.1.11.хувь хүний нууцыг хамгаалж ажиллах.	1
8.	Нягтлан бодогч		1
9.	Нярав		1
10.	Жолооч		1
11.	Нийт		11

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хорооны ажлын албаны албан хаагчдын дундаж цалингийн хэмжээг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны албан хаагчдын цалин хөлстэй адилтган тооцсон бөгөөд эдгээр албан хаагчид нь Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий

хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээний АА-6.1, АА-6.3 зэрэглэлээр цалинждаг байна.

Иймд албан хаагчдын дундаж цалингийн хэмжээг “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний АА-6.1 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээг тооцож гаргав.

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хорооны ажлын албаны албан хаагчдийн дундаж цалингийн хэмжээг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны албан хаагчдын цалин хөлстэй адилтган нь төрийн алба хаагчийн цалингийн АА-6.1 зэрэглэлд хамаарахаар тооцож “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний АА-6.3 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээгээр тооцож гаргав.

Хүснэгт №12 Цалингийн зэрэглэл. хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Сарын дундаж цалин
АА-6	691610	735470	779338	821779	864211	784,481 төгрөг

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой байдаг.

Хүснэгт №13 Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
-------------	-------------------------	------	-----------------

Үндсэн цалингийн дундаж хэмжээ	784,481		613,023
Нийтлэг зардал	784,481	15%	117,672
Дагалдах зардал	784,481	10%	78,448
Нэмэгдэл, урамшууллын зардал	784,481	30%	235,344
Нийт			1,044,487

Үүнээс үзэхэд Ажлын албаны нэг албан хаагчид зарцуулах цалин хөлс, түүнийг дагалдан гарах төрөөс даах зардлын дундаж хэмжээ 1,044,4887 /нэг сая дөчин дөрвөн мянга дөрвөн зуун наян долоон/ төгрөг байна.

Нэгтгэн үзвэл Ажлын албаны нийт албан хаагчдын тоогоор үржүүлбэл **11,489,357** /арваннэгэнсая дөрвөн зуун наян есөн мянга гурван зуун тавин долоон/ мянган төгрөгийн хүний нөөцийн зардлыг жил бүр төрөөс санхүүжүүлэх шаардлага үүснэ.

Материаллаг зардал

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох хэрэгтэй.

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хороо, түүний ажлын алба нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн зүгээс өгсөн мэдээлэлд үндэслэн байрны түрээсийн төлбөр болон бусад урсгал зардалд тооцогдох зардлыг энд тусгасан болно.

Хүснэгт №14 Нэг албан хаагчид гарах материаллаг зардал

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	485,557
зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж ¹¹	160,000
	Тавилга, эд хогшил ¹²	100,000

¹¹Нэг албан хаагчид хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа”-нд тусгаснаар 20% -иар тооцов.

	Барилга, байгууламж ¹³	65,670
	Нийт	325,670

Нэг албан хаагчид зарцуулах материаллаг зардлыг нарийвчлан тооцож гаргах боломжгүй байна. Иймд “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ны нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав.

Дээр тооцсон бүх зардал нийтдээ нэг албан хаагчийн “ажлын байрны дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлэх юм.

Хүснэгт №15 Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардал

Материаллаг зардал	Зардлын хэмжээ /төгрөг
Урсгал зардал	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	325,670
Нийт	1,952,317

Үүнээс харахад Хорооны ажлын албаны нэг албан хаагчид зарцуулах материаллаг зардлын хэмжээ дунджаар **1,952,317** /нэг сая есөн зуун тавин хоёр гурван зуун арван долоо/ төгрөг байна. Энэ нь нийт албан хаагчдын хувьд нэг жилд **21,475,487**/хорин нэгэн сая дөрвөн зуун далан таван мянга дөрвөн зуун хаян долоон/ төгрөгийн зардлыг төрд үүсгэхээр байна.

Бусадзардал

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж боловсруулах, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нэн шаардлагатай бараа материал худалдан авах гэх зэрэг зардлыг дурдаж болох юм. Хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагаас харахад “Хорооны ажлын албыг Хүний Эрхийн Үндэсний комиссын ажлын албаны нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэх болмжтой гэж бодож байна.”¹⁴ гэж тайлбарласан. Иймд Хорооны ажлын албаны тухайд дээр дурдсан бусад зардлуудыг энэхүү судалгаагаар тооцоолоогүй болно.

¹²Тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгаснаар 10%-иар тооцов.

¹³2013 онд ХЗЯ-наас хийсэн “Хөдлөх эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эрхийн барьцааны тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох судалгааны тайлан”-д дурдсан мэдээллийг ашиглав.

¹⁴Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн хурлын тэмдэглэлээс

Зардлыг нэгтгэн тооцох

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм. Энэ тохиолдолд Хороо түүний ажлын албанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох боломжгүй байсан тул ажлын албаны орон тоог хүний нөөцийн хэрэгцээ болгон авч үзсэн болно.

Хүснэгт №17 Нийт зардлын хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Хүний нөөцийн зардал	1,044,487	11	11,489,357
Материаллаг зардал	1,952,317	11	21,475,487
Нийт зардал			32,964,844

Дээрх хүснэгтээс харахад хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрөөс нэг жилд дунджаар **32,964,844**/гучин хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин дөрвөн/ төгрөгийн зардал үүсэхээр байна. Гэхдээ шинэ тутам байгуулагдах энэхүү энэхүү Хорооны ажлын албаны ажлын ачаалал, хуулийн хамрах хүрээнээс шалтгаалан бүтэц, орон тоонд өөрчлөлт орох эсэхэд анхаарах шаардлагатай юм.

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгасан Хороо, түүний ажлын албыг байгуулах болон Хорооны гишүүдийн сонгон шалгаруулах асуудлын хүрээнд төрд үүсэх зардлыг тоймлон тодорхойлохыг зорьсон. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн наад захын хэрэгцээг бусад адил чиг үүрэг бүхий байгууллагын бүтэц, орон тоо, цалин, хангамжтай дүйцүүлэх байдлаар тодорхойлсны үр дүнд төрөөс нэг жилд дунджаар **32,964,844**/гучин хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин дөрвөн/ төгрөгийн зардал жил бүр гарахаар байна.

Үрдүн, санал

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн төрд зардал үүсгэх 10, 11, 13 зүйл дэх зарим зохицуулалтын хүрээнд төрд үүсэх зардлаас нэн шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагааны зардлын хэмжээг урьдчилсан байдлаар тооцож гаргасан бөгөөд хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрөөс нэг жилд дунджаар **32,964,844**/гучин хоёр сая

есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин дөрвөн/ төгрөгийн буюу хүний нөөцийн зардалд 11,489,357, материаллаг зардалд 21,475,487 төгрөгийн зардал үүсэхээр байна.

Мөн Хуулийн төслийн 8 дугаар зүйлд тусгасан нийтлэг үүргүүд болон 9 дүгээр зүйл дэх Төрийн холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүргийн хүрээнд Улсын Их хурал /9.1./, холбогдох төрийн байгууллага, цагдаагийн байгууллага /9.2.1/, хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллага /9.2.2./, гадаад улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Консулын газар зэрэг Монгол Улсыг төлөөлөн гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй /9.3./ байгууллагуудад хүлээлгэсэн үүргийн хүрээнд үүсэх зардлыг тооцох шаардлагатай.

Хуулийн төслийн 12.1.4.хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч, Хүний эрхийн Үндэсний Комисст шилжүүлэн шийдвэрлүүлэх; 13.2.Хороо нь ажлын албатай байна. Хорооны ажлын албаны үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны бүтцэд бие даасан нэгж гүйцэтгэнэ.” гэж заасанд үндэслэн Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах Хорооны Ажлын албыг бие даасан байдлаар шинээр үүсгэн байгуулахаас илүүтэй Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албанд давхар хариуцуулан, хүний нөөцийг нэмэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд Хүний эрхийн Үндэсний Комисс бүтэц орон тоогоо УИХ-аар дахин хэлэлцэж батлуулах замаар одоо байгаа нөөц бололцоондоо тулгуурлан асуудлыг шийдвэрлэвэл төрөөс гарах зардлын хэмжээг багасгах боломжтой гэж үзлээ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны уйл ажиллагааны хөтөлбөр.
2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2000 он.
3. Засгийн газрын тусгай сангийн тухай 2006 он.
4. Засгийн газрын 2012 оны №78 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай”.
5. Засгийн газрын 2008 оны №110 тогтоолын хавсралт “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”.
6. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга.
7. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал.
8. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл.
9. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он.
10. Засгийн газрын 2016 оны №59 тогтоолын 4 дүгээр хавсралт.
11. Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам 2014 он
12. Засгийн газрын 2005 оны №233 тогтоолын 2 дугаар хавсралт.

Хоёр. Ном, гарын авлага, сэтгүүл

1. Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал. 2013 он. ХЗДХЯ, ГОУХАН
2. Хуультогтоомжийн тухай хууль, аргачлал, гарынавллага. 2016 он. ХЗДХЯ 2016 он
3. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл 2015 он.
4. Эмнести интернэшнлийн тайлан 2016/17 Дэлхий дахины хүний эрхийн байдал.
5. Б.Гүнбилэг. Монгол улс дахь Хүний эрхийн байгууллагуудын тухай цөөн үг. Хүний эрх. 2010.№2
6. Б.Болорсайхан. Ази, номхон далайн бүсийн хүний эрхийн байгууллагуудын үүсэл. Хүний эрх. 2015.№1
7. Х.Мөнхзул. Хүний эрхийн хамгаалагчдад хамгаалал хэрэгтэй юу?. Хүний эрх. 2010.№3

8. Б.Болорсайхан. Хүний эрхийн үндэсний байгуулагуудын магадлан итгэмжлэх үйл явцад Монгол улс. Хүний эрх. 2015.№2
9. Хүний эрхийн хамгаалалт, эрх зүйн шинэчлэлт. Нээлттэй нийгэм форум. 2015 он.
10. Монголд хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийг хамгаалах боломж. Нээлттэй нийгэм форум. 2005 он.

Гурав. Цахим эх сурвалж

1. <http://www.legalinfo.mn/>
2. <http://www.mn-nhrc.org/>
3. <https://www.shilendans.gov.mn/org/23>
4. <http://www.amnesty.mn/mn/aim-news/21456668107-hunij-erhijn-toloo-temcegchid-ruu>
5. <http://www.mn-nhrc.org/index.php?do=cat&category=188>
6. <https://www.amnestyusa.org/campaigns/human-rights-defenders/>
Amnesty International-ын гаргасан Хүний эрхийн хамгаалагчдын танилцуулга.
7. <http://www.ohchr.org/EN/Issues/SRHRDefenders/Pages/Defender.aspx>
НҮБ-ын дээд комиссын албанаас гаргасан хүний эрхийн хамгаалагчын тодорхойлолт
8. <https://www.consilium.europa.eu/uedocs/cmsUpload/GuidelinesDefenders.pdf>
Европын холбооноос гаргасан хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай
9. <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N16/247/09/PDF/N1624709.pdf?OpenElement>
НҮБ -ын ерөнхий хурлаас гаргасан “Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдал” сэдэвт дэлгэрэнгүй таницуулга
10. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0400_021V1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&Gender_select_all=0&GenderSingleSelect=_1&Year_select_all=0&YearSingleSelect=_201703&viewtype=table
2017 оны 3 дугаар улирлын байдлаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, өмчийн хэлбэр, хүйс, улирал, жилээр
11. ОӨУБЕГ-ын захиргааны статистикийн мэдээлэл /2017 оны 11 дүгээр сар/.
Эх сурвалж: <http://burtgel.gov.mn/index.php/news/statistical-rating-item>.

Дөрөв. Бусад эх сурвалж

1. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагын тэмдэглэл.
2. Хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсгийн гишүүд болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагын тэмдэглэл.

